



С.Хөвсгөл, доктор (Sc.D), профессор,
НХУС-ийн Уран зохиол, сэтгүүлзүйн тэнхимийн багш

ҮЛГЭР ДЭХ ХУРУУН ЧИНЭЭ ХҮҮГИЙН ДҮРИЙН ОНЦЛОГ

Резюме: В монгольском фольклоре существует сказка о Мальчике с пальчик /Хуруун чинээ хүү/. Этот образ тоже встречается в русском и японском фольклоре. Есть знаменитая сказка о Мальчике с пальчик Шарля Перро. Эти образы мальчика с ростом пальца или мизинца, являются хотя маленькими, но очень умными, хитрыми и в главном находчивыми. Они помогают своим родителям, приносит им имущество. В монгольском и русском сказках - они долгожданный сын, обычно бездетная семья хочет иметь сына хоть малюсенького.

В сказке Ш.Перро мальчик с пальчик родился ростом с пальца, и пять лет - очень маленького роста. Этим и отличается от других Мальчик с пальчиков. Но Он именно спасает своих братьев от великана-людоеда. В японской сказке Исунбоши, мальчик с пальчик спасает людей от дракона и становится царём. Этот образ мальчика с пальчик несёт в себе идеи о превосходстве человеческого разума. Нежели физических данных ум человека побеждает зло. А также философские вопросы о соотношении большого и маленького, которые были затронуты в знаменитых сатирах “Путешествие Гулливера” Ж.Свифта, “Гаргантюа и Пантагрюэль” Ф.Рабле.

А также в монгольских сказках есть образы “Мальчик с большого пальца” - Эрхийн чинээ хүү, “Пальчик с мизинца” - Чигчийн чинээ хүү. Это связана со считалками монгольского фольклора о Пяти пальцах руки: большой палец - эрхий, второй палец- долоовор, третий палец-средний палец, четвёртый палец- ядам хуруу, мизинец- чигчий хуруу.

Түлхүүр үг: дүрийн харьцуулал, их багын хэмжээ, уламжлалт дүр дүрслэл, аман зохил

Удиртгал

Аман зохиолын томоохон төрөл зүйл нь үлгэр юм. Үлгэр бол ард түмний амьдралын тусгал бөгөөд “Ард түмний амьдралын ном” гэж Фридрих Энгельс хэлжээ. Аман зохиолд их багын харьцаа дүрслэгдсээр ирсэн ба энэ нь туйлын том эсвэл жижиг зүйл гэж байдаггүй гэсэн санаа юм. Ялангуяа үлгэр, зүйр цэцэн үг, оньсого, ерөөл магтаал гээд аман зохиолын бүхий л төрөлд их багын харьцаа дүрслэгдсэн байдаг. Жишээ нь: зүйр цэцэн үгэнд:

Танилтай хүн талын чинээ

Танилгүй хүн алгын чинээ,

гэсэн бол оньсгонд:

Алгын чинээ өөхөнд

Амьтан бүхэн шамдана /нар/

гэжээ. Эндээс харахад их багын харьцааг ихэвчлэн зүйрлэх, чимэх аргаар бүтээсэн байна. Мөн уламжлалт хэмжүүрүүдээр дүрсэлжээ. Эдгээр хэмжүүрүүд нь гарын хуруу, малын бэлчээр, өвдөг тохой гээд баримжаалах аястай хэмжүүрүүд байна. Аман зохиолд эрхийн чинээ, хуруун чинээ, чигчийн чинээ хэмээн дүрсэлсэн нь хуруу шиг, чигчий шиг хэмээн зүйрлүүлж жижигхэн гэсэн санааг гаргасан байна. Уран зохиолд ч гэсэн зүйрлүүлж бага, жижиг эсвэл том аварга гэсэн санааг гаргадаг нь туйлын зүйрлэх аргагүй том, жижиг гэж байдаггүй гэсэн ойлголт юм. Жишээлбэл: Ж.Свифтын “Гулливерийн аялал” зохиолын “Гулливер одой хүмүүсийн оронд” гэсэн нэгдүгээр бүлэгт одой хүмүүсийг “Гулливер юу болохыг үзэх гэж хялайн харвал гар хөлтэй, цагаан дуулгатай, нум сум барьж, саадаг агссан яг л хүн шиг бяцхан амьтан зогсож байх нь тэр. Үгүй мөн хачин аа. Бяцхан хүний нуруу эрхий хуруунаас өндөргүй. Тийм бяцхан таван хүн Гулливерийн алган дээр уужуухан багтахаар ажээ... Далайн шуурганд

туугдаж Гулливерийн ирсэн орныг Одой орон гэх буюу энд гагцхүү одой хүмүүс оршин суудаг байна. Одойн оронд ургадаг хамгийн өндөр мод нь манай үхрийн нүдний сөөгнөөс ч өндөргүй, хамгийн том байшин нь манай жирийн нэг бичгийн ширээнээс ч намхан.” хэмээн дүрсэлсэн байдаг бол “Гулливер уул шиг хүмүүсийн оронд” гэсэн хоёрдугаар хэсэгт “Бүр саяхан жилийн өмнө одой хүмүүсийн оронд би уул шиг хүн байж билээ. Тэгэхэд хэд хэдэн морьтой хүнийг халаасандаа хийж байсан, дайсны цэргийн бүх флотыг нэг гараараа чирээд ирж байсан сан. Тэгтэл одоо уул шиг хүмүүсийн дунд өөрөө одой хүн мэт...” хэмээн өөрийн эрхгүй бодов” гэх зэргээр их багын харьцааг дүрсэлжээ. Харин Монгол ардын үлгэр туульст “Эрхийн чинээ хүү”, “Чихэн чинээ хүү”, “Сүүлэн чинээ хүү”, “Нэг төө биет хоёр төө сахалт”, “Ван чигчий хааны үлгэр” гэх мэт их багын харьцааг дүрсэлсэн олон үлгэр домог байдаг ажээ. Эдгээр үлгэрүүдийн төсөөтэй болон ялгаатай талыг харьцуулан судлах нь энэхүү өгүүлэлийн зорилго болно.

Үндсэн хэсэг

1. “Монгол үлгэр дэх хуруун чинээ хүүгийн дүр”

Монгол үлгэрт хуруун чинээ биетэй бяцхан хүүгийн дүрийг бие жижиг ч арга ухаантай, цовоо сэргэлэн, зальтай мэтээр дүрсэлсэн байдаг. Энэ нь хэдий бие жижиг ч гэсэн ухаанаараа олон зүйлийг хийж болдог гэдгийг харуулсан юм. Эдгээр эрхийн чинээ хүүгийн дүр нь туйлын жижиг биш аливаа зүйлтэй харьцуулан жишиж, төө хэрийн өндөртэй, эрхий хуруунаас өндөргүй гэх мэт байж болох хэмжүүрүүдийг гаргасан хэдий ч жирийн хүний дэргэд өчүүхэн жижиг гэсэн санааг гаргажээ. Мөн үр хүүхэдгүй айл үр хүүхэдтэй болохыг чин сэтгэлээсээ хүсч хуруун чинээ ч хамаагүй хүүтэй болохсон гэж хүсч бяцхан хүүгээ ихэд хайрлан халамжилдаг. “Эрхийн чинээ хүү” үлгэрт: “Сар жил өнгөрөвч Эрхийхэн хүү өсөж том болсонгүй. Сая төрсөн юм шиг л бяцхан хэвээр байх юм гэнэ. Харин тэр нүүрэндээ гэрэлтэй, нүдэндээ галтай, ухаалаг, сэргэлэн хүү байжээ” хэмээн өгүүлдэг бол “Сүүлэн чинээ хүү” үлгэрт: “Сүүлэн хүү чи тийм чадалтай юм бол миний хатны алтан бөгжийг өнөө орой аваад орхи гэжээ” хэмээн хуруун чинээ хүүгийн арга ухааныг шалгаж байна.

Монгол хэмжүүрт “чинээ” гэдэг үгийг ашигласан нь аливаа зүйлийн их, бага, том жижгийг хэмжихдээ ойролцоо зүйлээр баримжаалан хэлдэг байсантай холбоотой

ажээ. Эрхий, чигчий, ядам, төө гэх мэт хуруу гарын хэмжээ нь өчүүхэн жижиг зүйлийн уртыг хэмжих нэгж бөгөөд монгол хэмжүүрт эрхий нь /7-9 см/, чигчий нь мөн тийм урттай, төө нь /18-20см/ байдаг ажээ. Тэгэхлээр энэ нь туйлын бага биш харин байдаг байж болох хэмжээний гэсэн үг. Монгол үлгэрийн хуруун чинээ хүү бол арга ухаанаар алт мөнгө, эд хөрөнгө, эрх мэдэл олж авч байгаа дүр болно.

2. Гадаадын үлгэр дэх хуруун чинээ хүүгийн дүр

Орос болон Япон ардын үлгэрт хуруун чинээ хүүг мөн л гарын хурууны өндөртэй зүйрлэн бичсэн нь уран зохиолын их багын харьцааг харуулсан. Өчүүхэн жижиг биетэй ч эр зоригтой эрэмгий чадалтай, арга ухаантай хэмээн дүрсэлсэн нь Японы “Иссун Бүши”, Оросын “Мальчик-с-пальчик” зэрэг үлгэрээс харагдаж байна. Эдгээр үлгэрт хуруун чинээ хүү өөрийн хүчээр мангасыг дарж, хааны гүнжийг аварч, хаан сууж амар сайхан жаргаж байгаа тухай гардаг.

№	Үлгэрийн нэр	Төстэй тал	Ялгаатай тал
1.	Эрхий чинээ хүү	-Эрхий хуруунаас өндөргүй -Цовоо сэргэлэн арга ухаантай -Сая төрсөн мэт жижигхэн хэвээрээ -Мал амьтны чихэн дотор суудаг -Бардам зантай -Аав ээж нь ихэд хайрладаг -Хүүхэдгүй айлын ганц хүү болон төрдөг -Хүмүүс доог тохуу хийж басамжилдаг -Хулгай хийдэг -Мал амьтны ходоодонд ордог -Амар сайхан жаргадаг -Айлын хотонд очоод хашгирдаг ("Эрхийн чинээ хүүгийн үлгэр" х.189)	-Хаантай уулздаггүй -Зэндмэнэ эрдэнэ хулгайлдаггүй -Хаан болдоггүй
2.	Хуруун чинээ хүү	-Хуруу шиг жижигхэн -Овтой мэхтэй-Бардам зантай -Аав ээж нь ихэд хайрладаг -Хүүхэдгүй айлын ганц хүү болон төрдөг -Хүмүүс доог тохуу хийж басамжилдаг -Хулгай хийдэг -Мал амьтны ходоодонд ордог -Амар сайхан жаргадаг	
3.	Чихэн чинээ хүү	-Чихэн чинээ өндөртэй -Аргатай овтой ухаантай -мал амьтны ходоодонд ордог -айлын хотонд очоод хагширдаг -Хүмүүс доог тохуу хийж басамжилдаг -Хулгай хийдэг - Бардам зантай -хааны гутлын ул малгайн жинсийг авдаг -хаан сууж амар сайхан жаргадаг -хүүхэдгүй айлын хүү болон төрдөг ("Чихэн чинээ хүүгийн үлгэр" х. 161)	-Чихэн чинээ хүү алга болоод малын ходоодонд ордог тэгээд хажуугаар явсан залууст эрдэм чадла харуулна гэж хулгай хийдэг бол сүүлэн чинээ хүү өөрийн хүсэлтээр хулгай хийдэг -гэртээ суудаггүй - хатны алтан бөгжийг авдаг -хааны зэндмэнэ эрдэнийг авдаг
4.	Сүүлэн хүү	-Сүүлэн чинээ бяцхан хүү -Сүрхий чадамгай -айлын хотонд очоод хагширдаг -Хүмүүс доог тохуу хийж басамжилдаг -Хулгай хийдэг -Бардам зантай хүүхэдгүй айлын хүү болон төрдөг -хааны гутлын ул малгайн жинсийг авдаг -хаан сууж амар сайхан жаргадаг ("Сүүлэн хүү" х.179)	
5.	Орос үлгэр	-хуруун чинээ бяцхан хүү -хүүхэдгүй айлын хүү болон төрдөг -мангасыг дардаг -хулгай хийдэг -цовоо сэргэлэн зальтай -бардам зантай -хүмүүс басамжилдаг	- мангасыг дардаг - хааны гүнжийг авардаг
6.	Япон үлгэр	-Насанд хүрсэн хүний хуруунаас өндөргүй -хүүхэдгүй айлын хүү болон төрдөг -хулгай хийдэг -цовоо сэргэлэн зальтай -бардам зантай -хүмүүс басамжилдаг -хаан болдог	

ДҮГНЭЛТ

Аман зохиол болон дэлхийн уран зохиолд их багын харьцааг ямагт дүрсэлдэг. Энэ нь манай үлгэр туульс болоод Орос, Япон орны үлгэрээс харагдаж байна. Аливаа зүйлийг уран зохиолд дүрслэхдээ яруу дүрслэх хэрэглүүрийг ашигладаг бөгөөд тэрхүү дүрслэлийг их багын харьцаан дээр тулгуурлан заавал харьцуулан зүйрлүүлэн бичдэг ажээ. Хуруун чинээ хүү гэсэн санааг янз бүрийн жижигхэн, өчүүхэн зүйлтэй зүйрлэн харьцуулан бичих нь уран зохиолд элбэг байдаг гэдгийг дээр дурдсан үлгэр домог, зохиол бүтээл харуулж байна. Мөн монгол хэмжүүрүүдийг ашиглан дүрсэлсэн үнэхээрийн өчүүхэн жижиг гэсэн санааг өөрийн ёс заншилд ойртуулан дүрсэлж өгсөн нь уран зохиолын их багын харьцааны хамгийн том жишээ юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Цэрэнсодном, (2000). *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Улаанбаатар

Дарь, Ж. (2010). *Монгол ардын үлгэр ном түүвэр*. Улаанбаатар.

Ловор, Г. (2011). *Хуруун чинээ хүүгийн үлгэр түүвэр*. Улаанбаатар.

Цэрэнсодном, Д. (2012). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар.

Үнэнбаяр.blogspot.com

Barbagsh.blogspot.com